



**ОЧИР УНДРАА ХХК-ИЙН “ХИМИЙН БОДИС
ПИРОТЕХНИКИЙН” АГУУЛАХЫН 2022 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2022 он**

АГУУЛГА

ОРШИЛ.....	1
1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	2
i. Төслийн нэр.....	2
ii. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж байгууллага.....	2
iii. Төслийн байршил, хэрэгжих орчны тойм зураг.....	2
iv. Төслийн зорилго.....	3
b. Төслийн үйл ажиллагаа.....	3
c. Химийн бодис тээвэрлэлт.....	4
d. Төслийн талбайн үндсэн байгууламжууд.....	5
i. Аммонийн нитратын агуулах.....	7
ii. Пиротехникийн хэрэгслийн агуулах.....	8
iii. Химийн бодисын агуулах.....	8
iv. Харуул хамгаалалт.....	9
v. Аянга зайлуулагч.....	9
e. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ.....	10
2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ.....	11
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	12
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАХ Тайлан.....	13
4.1 Гол зорилт.....	13
4.2 Хамрах хүрээ.....	13
4.3 Байгаль орчны менежментийн тайлан.....	13
4.4 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний тайлан.....	14
4.5 Ногоон байгууламжийн тайлан.....	17
4.6 Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах тайлан.....	17
4.7 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох тайлан.....	17
4.8 Түүх, соёлын өвийг хамгаалах тайлан.....	17
4.9 Хог хаягдлын менежментийн тайлан.....	18
4.9 Осол, эрсдэлийн менежментийн тайлан.....	20
Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ.....	21
4.10 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	22
ДҮГНЭЛТ.....	24

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

<i>Хүснэгт 1. Төслийн булангийн цэгийн координат</i>	2
<i>Хүснэгт 2. Химийн бодисын агуулахад хадгалагдах химийн бодисууд</i>	3
<i>Хүснэгт 3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт</i>	12
<i>Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний тайлан 2022 онд</i>	15
<i>Хүснэгт 5. Ногоон байгууламжийн тайлан</i>	17
<i>Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн тайлан</i>	19
<i>Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн тайлан</i>	20
<i>Хүснэгт 8. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ</i>	21
<i>Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр</i>	23

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

<i>Хүснэгт 1. Төслийн булангийн цэгийн координат</i>	2
<i>Хүснэгт 2. Химийн бодисын агуулахад хадгалагдах химийн бодисууд</i>	3
<i>Хүснэгт 3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт</i>	12
<i>Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний тайлан 2022 онд</i>	15
<i>Хүснэгт 5. Ногоон байгууламжийн тайлан</i>	17
<i>Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн тайлан</i>	19
<i>Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн тайлан</i>	20
<i>Хүснэгт 8. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ</i>	21
<i>Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр</i>	23

ОРШИЛ

Очир-Ундраа ХХК нь 2000 онд анх уул уурхайн тоног төхөөрөмжийн импорт, худалдааны чиглэлээр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан. 2002 оноос эхлэн БНХАУ-аас пиротехникийн хэрэгсэл, төрөл бүрийн салют импортлон худалдаалах ажлыг эрхлэн явуулж байгаа бөгөөд эдүгээ агуулахдаа өргөтгөл хийж олон улсын жишигт нийцсэн химийн бодисуудыг оруулж ирэн нэр төрөл, тоо хэмжээг өргөжүүлэх үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.

Очир-Ундраа ХХК-ийн “Химийн бодис, пиротехникийн агуулах” төслийн үйл ажиллагаанд БОАЖЯ-ны 2021.04.02 ны өдрийн 13/1488 тоот ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасны дагуу энэхүү байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Баялаг эко ХХК боловсрууллаа.

Төслийн БОННУ-ний тайланг БОНХ-ийн сайдын 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А117 тоот тушаалын 2-р хавсралтаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх аргачлал”, БОМТ-ын төлөвлөгөөг БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам дагуу боловсруулав. Химийн эрсдэлийн үнэлгээг А-50/378/656 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Химийн хорт болон аюултай бодисын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэлээ.


“Химийн бодис, пиротехникийн агуулах” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хүрээнд төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоож, тэдгээр сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ, химийн бодисын эрсдэлийн үнэлгээ, болзошгүй эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ зэргийг боловсруулан, цаашид Очир-Ундраа ХХК-ийн байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн 2022 оны төлөвлөгөөг боловсруулан, холбогдох зардлуудыг тусгав.

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

- i. **Төслийн нэр** Химийн бодис пиротехникийн агуулах төсөл
- ii. **Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж байгууллага**
- Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: Очир-Ундраа ХХК
 - Улсын бүртгэлийн дугаар: 9011122089
 - Регистрийн дугаар: 2659603
 - Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай 8/1, Сити Тауэр бизнес төв, 17 давхарт
 - Утас: +976-75757979, +976-11- 326466

iii. Төслийн байршил, хэрэгжих орчны тойм зураг

Очир-Ундраа ХХК-ийн Химийн бодис пиротехникийн агуулах нь Налайх дүүргээс 5 км зайд, Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрладаг. 1.299 га үйлдвэрийн зориулалттай газар үйл ажиллагаагаа явуулдаг. Төслийн талбайн булангийн цэгүүдийг Хүснэгт 1-т, байршлын зургийг Зураг 2-т харуулав.



Зураг 1

Зураг 2. Агуулахын байршил

Хүснэгт 1. Төслийн булангийн цэгийн координат

№	X	Y	Урт
1	668474.61	5290420.46	214.07
2	668688.58	5290426.63	73.62
3	668691.40	5290353.07	140.39
4	668551.07	5290349.54	104.28

iv. Төслийн зорилго

Очир - Ундраа ХХК нь Олон улсын жишигт нийцсэн химийн бодисуудыг МЕРА ХХК, Бүтээгч ХХК, Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр, Бор Өндрийн Уулын баяжуулах үйлдвэр, Шивээ Овоо ХК, Багануур ХК, Оюу Толгой ХХК зэрэг Монгол улсын томоохон уурхай, компаниудад нийлүүлэн, химийн бодис, түүхий эдээр хангах, Шинэ жил, Улсын баяр наадам зэрэг томоохон шоу цэнгүүнд пиротехникийн үйлчилгээ үзүүлэх, хадгалах зорилготой үйл ажиллагаагаа явуулдаг байна.


в. Төслийн үйл ажиллагаа

Агуулахад хадгалдаг химийн бодисуудыг Хятад улсын Shandong Guanghe Trading Co.Ltd., Shijia Zhuang Xinlongwet Chemical Co.,Ltd, Shijiazhuang Xinlonggwei Chemical Co.,Ltd компаниудтай гэрээ хийнэ импортлон оруулж ирдэг ба бодисын төрөл тоо хэмжээг нэмж 11 төрлийн химийн бодис , 1 төрлийн пиротехникийн хэрэгсэл /салют/ оруулж ирэхээр төлөвлөж байна. Үүнд: Натрийн нитрат, Этиленгликоль, Цууны хүчил гэх зэрэг бодисууд оруулж ирэхээр байна. Иймд агуулахад нийт 16 төрлийн бодисуудыг хадгалахаар төлөвлөөд байна.




Хүснэгт 2. Химийн бодисын агуулахад хадгалагдах химийн бодисууд

№	Олон улсын нэршил	Монгол нэр	Химийн томьёо	CAS дугаар	Хэмжээ, 1жилд /тн/
1	Аммонийн нитрат	Ammonium nitrate	NH ₄ NO ₃	6484-52-2	10000
2	Аммонийн нитрат, сүвэрхэг	Ammonium nitrate, porous	NH ₄ NO ₃	6484-52-2	20000
3	Натрийн нитрит	Sodium nitrite	NaNO ₂	7632-00-0	40
4	Эмульгатор	Emulgator			140
5	Хөнгөн цагааны нунтаг	Aluminum powder	Al	7429-90-5	40
Шинээр нэмэгдэж буй химийн бодисууд					
1	Мочевин	Urea	CN ₄ N ₂ O	57-13-6	200
2	Геомочевин	Thiourea	CN ₄ N ₂ S	62-56-6	120
3	Натрийн нитрат	Sodium nitrate	NaNO ₃	7631-99-4	300
4	Цууны хүчил	Acetic acid	CH ₃ COOH	64-19-7	60
5	Этиленгликоль	Ethylene glycol	C ₂ H ₆ O ₂	107-21-1	240
6	Давсны хүчил	Hydrochloric acid	HCL	7647-01-0	500
7	Парафин	Paraphine			500
8	Натрийн гипохлорит	Sodium hypochlorite	NaClO	7681-52-9	220
9	Хүхэрт натри	Sodium sulphide	Na ₂ S	1313-82-2	3000
10	Шингэн шил	Sodium metasilicate	Na ₂ SiO ₃	6834-92-0	240
11	Хүхрийн хүчил	Sulphuric acid	H ₂ SO ₄	7664-93-9	200

Химийн бодисын агуулахад бодис бүрийн шинж чанарыг харгалзан өөр, өөр өрөөнд доорх зурагт үзүүлсний дагуу эгнүүлэн хадгалах юм.



Таних тэмдэг

-  Подон 120x100см
-  Аммонийн нитрат /Биг баг 90x90x150см/
-  Аммонийн нитрат /40 кг 50x20x25см/

Тайлбар

- Подон Бигбаг-н агуулахад 83 ширхэг, шуудаайтай агуулахад 76 ширхэг
- Бигбаг нэг агуулахад 97 ширхэг /82,450 кг*2=164,900 кг/
- Шуудай /40 кг/ нэг агуулахад 4912 ширхэг /196,480 кг, 8 давхарлаж өрнө/
- Нийт 242 ширхэг подон
- 361,380 кг аммонийн нитрат

Зураг 3. Агуулахад химийн бодисыг байрлуулах схем зураг




с. Химийн бодис тээвэрлэлт

Очир-Ундраа ХХК нь химийн бодис пиротехникийн хэрэгслийг Эрээн-Замын Үүд, Хиагт-Алтанбулагийн авто зам, Сүхбаатар-Наушкийн төмөр замын боомтуудаар химийн бодисуудаа импортолдог. Гаалийн бүрдүүлэлт хийсний дараа ачаа тээврийн Огоот ХХК-аар тээвэрлүүлэн агуулахад хүргүүлдэг байна. Огоот ХХК-тай №Г-21-003 дугаартай “Ачаа тээвэрлэлт үйлчилгээ үзүүлэх болон хамтын ажиллагаа”-ны гэрээ” байгуулан хамтран ажилладаг. Тус компани нь “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны журам”-аар зөвшөөрөл авсан тээврийн хэрэгслээр аммиакийн шүү, химийн бодис, пиротехникийн хэрэгслүүдээ тээвэрлэн хүргэдэг. Гэрээ, тээврийн хэрэгслүүдийн зөвшөөрлийг хавсралтаар оруулав.

d. Төслийн талбайн үндсэн байгууламжууд


Төслийн хашаа нь хойд талаараа МЕРА ХХК-ийн хашаатай залгаа, баруун, зүүн, урд талаараа 2 метрийн өндөртэй торон хашаа барьж байгуулсан. Торон хашааны гадуур 50 метрийн радиуст “Хориотой бүс” анхааруулах тэмдэг тавьсан. Эргэн тойрны дэвсгэр газарт хашаанаасаа 5 метрийн зайд 0.5 метрээс багагүй гүнтэй үер ус ба гал түймрээс хамгаалах шуудуу татсан байна. Зүүн урд талаасаа орох хаалгатай ба хаалганаас зүүн урагш 200 м газарт “Цугларах цэг” байршуулсан байна.

Зураг 4. Агуулахын хашаа болон үерийн уснаас хамгаалах сүвгийн зураг



Хавсралт №3

Химийн бодис, пиротехникийн хэрэгслийн агуулахуудын палан зураг



Тайлбар

1. Харуулын байр
2. Аммонийн нитратын агуулах /төмөр чингэлэг/
3. Аммонийн нитратын агуулах /сэндвич/
4. Хамгаалалтын далан
5. Аянга зайлуулагч
6. Хамгаалалтын торон хашаа
7. Ус зайлуулах шуудуу
8. Дайрга асгах талбай
9. Агуулахын гэрэлтүүлэг
10. Галын эсэргүүцэх байгууламж
11. Газардуулагч
12. Тэсрэх материалын агуулах /төмөр чингэлэг/
13. Бандан кран байрлах талбай
14. Агуулахын үүдэн хэсгийн цементэн талбай

Танилцсан	Гүйцэтгэх захирал	Г.Мөнхсүл	Гарын үсэг	Химийн бодис, пиротехникийн хэрэгслийн агуулахын төсөл	ОЧИРУНЦРАА
Хиансан	Инженер	Б.Болдбаатар		Химийн бодис, Пиротехникийн хэрэгслийн агуулахын палан зураг	"Очир Ундраа" ХХК
Зурсан	Мастер	Л.Басдрж			Огноо
					Масштаб 1:1000

Зураг 5. Химийн бодис, пиротехникийн хэрэгслийн агуулахын палан зураг

Химийн бодис пиротехникийн агуулах төсөл нь барилга байгууламжийн хувьд аммонийн нитратын агуулах, пиротехникийн хэрэгслийн агуулах, химийн бодисын агуулах гэсэн 3 үндсэн агуулахын барилгаас бүрдэнэ. Дотроо анхны тусламжийн өрөө, зааварчилгаа өгөх, хувцас солих өрөөг тохижуулсан байна.



Зураг 6. Химийн бодисын агуулах



Зураг 7. Анхны тусламжийн өрөө




Зураг 8. Хувцас солих болон зааварчилгаа өгөх өрөө

i. Аммонийн нитратын агуулах

Аммонийн нитратын агуулах нь 50.4 м урт, 15 м өргөн, 4 м өндөр, 750 м.кв талбайтай, 400 тн багтаамжтай төмөр каркасан сэндвичин барилга. 17x15 хэмжээтэй, автомашины дөрвөн том хаалгатай, нэг явган хаалгатай, 17x15 хэмжээтэй, автомашины дөрвөн том хаалгатай, 12x15 хэмжээтэй, автомашины гурван том хаалга, нэг явган хаалгатайгаар нийт гурван тасалгаатай баригдсан.


Аммонийн нитратын агуулахын схем зураг



Зураг 9. Аммонийн нитратын агуулахын схем зураг

ii. Пиротехникийн хэрэгслийн агуулах


Пиротехникийн хэрэгслийн агуулах нь 40 тн багтаамжтай 5 ширхэг газрын дээрх чингэлэг агуулах байрлуулсан.



Зураг 10. Пиротехникийн хэрэгслийн агуулахын схем зураг

iii. Химийн бодисын агуулах

Химийн бодис хадгалах 40 тн багтаамжтай 3 ширхэг газрын дээрх чингэлэг агуулахуудыг зэрэгцүүлэн байрлуулсан байна.



iv. Харуул хамгаалалт

Агуулахыг нийтэд нь хянах боломжтой шалган нэвтрүүлэх байр нь хашааны зүүн урд байрлах бөгөөд хамгаалалтын тусгай хэрэгсэл болон холбоогоор бүрэн хангагдсан гэрээт харуул хамгаалалтын албыг 24 цагаар ажиллуулдаг.

v. Аянга зайлуулагч

Нийт 4 аянга зайлуулагчтай. Химийн бодисын агуулахын зүүн тал 1 ширхэг, Аммонийн нитратын агуулахын хоёр талд 2 ширхэг, пиротехникийн хэрэгслийн агуулахын баруун талд 1 ширхэг аянга зайлуулагч байрлуулсан.



Зураг 12. Төслийн талбайн барилга байгууламж болон аянга зайлуулагчид

Гал эсэргүүцэх цэг: Нийт 4 галын сарайтай. Химийн бодисын агуулахын зүүн тал 1 ширхэг, Аммонийн нитратын агуулахын хоёр талд 2 ширхэг, пиротехникийн хэрэгслийн агуулахын зүүн урд талд 1 ширхэг галын сарай байрлуулсан.



Зураг 13. Төслийн талбай дах гал унтраах хэрэгсэл

е. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Төслийн талбайд ажилчид байрлахгүй бөгөөд харуул хамгаалалтын ажилчид болон химийн бодис ачиж зөөх ажилчид тухай бүрд ирж ажиллах бөгөөд ахуйн гаралтай хог хаягдал маш бага хэмжээтэй гарахаар байна. Үүнийг зэргэлдээ орших МЕРА ХХК-ийн ахуйн хог хаягдалтай нийлүүлэн хаядаг байна. Харин зарим тохиолдолд химийн бодисын сав баглаа боодлын хог хаягдал гарч болзошгүй учир энэ төрлийн хог хаягдлыг Төв аймгийн Сэргэлэн сумын I багийн нутаг, IV зөрлөгийн орчимд химийн хорт болон аюултай бодисын сав, баглаа боодол дахин боловсруулдаг “Түмэн эгшиг” ХХК-тай 2020.01.22-нд химийн бодисын хаягдал, баглаа боодол шилжүүлэх гэрээ байгуулсан байна.

2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

1. БАЙГАЛЬ ОРЧНЫ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Физик газар зүй: Очир-Ундраа ХХК-ийн хэрэгжүүлж буй “Химийн бодис пиротехникийн агуулах төсөл нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хороонд байрлана. Төсөл хэрэгжих бүс болох Улаанбаатар хот нь Монгол орны физик газар зүйн мужлалаар Хангай Хэнтийн уулархаг их мужийн хэсэгт, тухайлбал Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд шувтраг үзүүрт Туул голын өргөн хөндий, ай сав цутгал голуудын бэлчирт байрладаг.

Уур амьсгал: Улаанбаатар хот нь эх газрын эрс тэс уур амьсгалын нөхцөл нь уулсын байрлал, тэдгээрийн хажуугийн зүг зовхисын байдал, хотгор гүдгэрийн ерөнхий төрхтэй уялдан хөрс, ургамлан нөмрөг, гадаргын ус, улирлын хөлдөлт гэсэлт, бичил уур амьсгал бүрэлдэн тогтох онцлог нөхцөлийг бүрдүүлдэг. Энэ нь ялангуяа уулсын ам хөндий, ах өвөр хажууд тодорхой ажиглагддаг. Уулсын ам хөндийнүүдээр урсах гол горхины ус нь ихэнх тохиолдолд адаг орчимдоо сэвсгэр хурдас доогуур шурган ордог боловч хур бороо элбэг үед түр зуур ил урсан Туул голд цутгадаг. Туул гол, түүний цутгал гол горхины үндсэн тэжээл нь зун, намрын хур борооны ус юм. Ийнхүү эх газрын эрс тэс уур амьсгалын нөлөөгөөр хур тунадас бага, жил хоногийн температурын ялгаа их бүс нутаг юм.

Хөрсөн бүрхэвч: Төсөл хэрэгжих Налайх дүүргийн нутаг нь байгалийн бүсийн хувьд ойт хээр бүсэд хамрагдана. Энэ дэд бүс нутагт Хар хүрэн хэв шинжийн хөрс зонхилон тархдаг байна. Мөн Хар шороон болон Аллювын хэв шинжийн хөрснүүд дагалдах байдлаар багахан талбайд тархдаг.

Амьтны аймаг: Амьтан, ургамлын аймгийн экосистемийн шинж төрх бүрэн алдагдаж, амьтны зүйлийн бүрдэл нь хот суурин, хүний ойр орчимд амьдардаг синантроп зүйлүүд суурьших болжээ. Улаанбаатар хотод амьтны аймгаас хамгийн өргөн тархсан цөөн зүйлийн шувуу, шавж, хөхтөн судалгаагаар тодорхойлогдсон байдаг. Тухайлбал шувуудын дотроос тоо толгойн хувьд оронгийн ба хээрийн бор шувуу, шаазгай, сохор элээ, хөх бор тагтаа, хар элээ, хөхтний дотроос дагуур зурам, хэргэлзий оготно, гэрийн хулгана, үлийн цагаан оготнууд байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Байгаль орчин: Нийслэлийн Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулж байгаа Очир-Ундраа ХХК-ийн Химийн бодис пиротехникийн агуулах төслийн үйл ажиллагаа болох химийн бодис хадгалалт, тээвэрлэлт, ачиж буулгах үйл ажиллагаанаас агаарын чанар, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг зэрэг байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдэд шууд болон дам нөлөө үзүүлж болзошгүй байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг байгаль орчны бүрэлдэхүүн тус бүр дээр тооцсон ба нийт 11 сөрөг нөлөөллийг үзүүлэхээр байна. Үүнээс 1 буюу 9 % нь бага, 5 буюу 45.5 % нь дунд, 5 буюу 45.5% нь их гэсэн үнэлгээний зэрэгт хамаарагдаж байна. Үүнээс үзэхэд төслөөс байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь дундаас их зэрэглэлд хамаарч байна.

Хүснэгт 3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг	Нөлөөллийн үнэлгээ			Нийт
	Бага	Дунд	Их	
Агаарын чанар		1	2	3
Газрын доорх ус			1	1
Ургамлан нөмрөг		3		3
Хөрсөн бүрхэвч	1	1	2	4
Нийт (тоогоор)	1	5	5	11
Нийт (хувиар)	9%	45.5%	45.5%	100%

Хүний эрүүл мэнд: Химийн бодисын хадгалалт тээвэрлэлт, ачиж буулгах үйл ажиллагаанаас үүдэн тухайн үед ажиллах ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй. Ажилчдын эрүүл мэндэд учруулах нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зөвлөмж, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг чанд даган мөрдөж, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийг бүрэн өмсөж хэвшсэнээр эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах, арилгах бүрэн боломжтой байна.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАХ ТАЙЛАН

4.1 Гол зорилт

Очир-Ундраа ХХК -ийн Химийн бодис пиротехникийн агуулах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаврыг тогтмол хянах, хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй.

4.2 Хамрах хүрээ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд Очир-Ундраа ХХК-ийн Химийн бодис пиротехникийн агуулах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн бөгөөд төсөл хэрэгжүүлэгч үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш жил бүр энэхүү үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай. Ингэхдээ байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дагавар, бодит байдалтай уялдуулан улам баяжуулж, сайжруулан мөрдлөг болгох хэрэгтэй. Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11 сарын 1-ний дотор Налайх дүүргийн ЗДТГ-г танилцуулан, 12 дугаар сард багтаан БОАЖЯ-д хүргүүлж дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг БОАЖЯ-аар батлуулах үүрэгтэй.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг нөлөөлөлд өртөж болзошгүй байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзэж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг эхний таван жилээр тооцсон болно.

4.3 Байгаль орчны менежментийн тайлан

Төслийн БОМТ хэрэгжүүлэх 2022 онд **23,0747,719** зарцуулсан бөгөөд зардлуудын хураангуйг доорх хүснэгтэд харуулав.

№	Байгаль орчны менежментийн тайлан		Нийт зардал төг
1	Байгаль орчныг хамгаалах тайлан	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний тайлан	6,621,719₮
		Ногоон байгууламжийн тайлан	1,500,000₮
		Хог хаягдлын менежментийн тайлан	3,240,000 ₮
		Осол эрсдэлийн менежментийн тайлан	2,805,000 ₮
		Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний тайлан	8,500,000 ₮
2	Орчны хяналт шинжилгээний тайлан	Орчны хяналт шинжилгээний тайлан	408,000 ₮
Нийт зардал			23,0747,719 ₮

4.4 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний тайлан

Төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөрс болон ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах, усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, амьтны аймагт үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах арилгах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн авч үзсэнийг Хүснэгт 4-д бүрэн эхээр харуулав. Төсөл хэрэгжүүлэгч энэхүү БОХТ-г бүрэн хэрэгжүүлсэн нөхцөлд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, тэдгээрийг бууруулах, арилгах бүрэн боломжтой.

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний тайлан 2022 онд

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
Агаар орчин									
1	Агуулахын дотоод агаарын чанар муудах,	Агуулахад агааржуулалтын систем суурилуулах	Агуулахын дотор орчин	Гүйцэт гэлээр			1 500 000₮	Агааржуулалтын систем байрлуулсан.	
2	Тээврийн хөдөлгөөнөөс агаарт тоосжилт үүсэх	Хучилтгүй зам дээр тээвэр хийх машины хурдыг ачаатай үед 20 км/цаг, ачаагүй үед 30 км/цагаас хэтрүүлэхгүй байх.	Замууд	-	-	-	951 719₮	Хурд хэтрүүлэхгүй байх тэмдэглэл хийж байршуулсан	
3	Химийн бодисын буруу хадгалалтаас үүдэн химийн бодис алдагдах агаарын чанарт сөргөөр нөлөөлөх, галын аюул гарах	Химийн бодис, материалын хадгалалтын нөхцөлийн стандартыг нарийн баримталж уурших, халах, тэлэх нөхцөлөөс бүрэн сэргийлж ажиллах. Химийн бодисыг хадгалахдаа ХАЛМ-д заасны дагуу хадгалах.	Агуулахын ойр орчим	-	-	-	-	Үйл ажиллагааны турш	
Усан орчин									
4	Химийн бодис буруу хадгалалтаас үүдэн химийн бодис их хэмжээгээр алдагдсан тохиолдол гүний усыг бохирдуулж болзошгүй.	Химийн бодис, материалын хадгалалтын нөхцөлийн стандартыг нарийн баримталж уурших, халах, тэлэх нөхцөлөөс бүрэн сэргийлж ажиллах. Химийн бодис их хэмжээгээр алдагдсан тохиолдолд авах шуурхай арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах.	Агуулахын талбай	Иж бүрдэл	Осол эрсдэлийн менежментийн хэсэгт тусгагдсан	жил бүр	770 000₮	Иж бүрдэл байрлуулсан.	
Хорсон бүрхэвч, газрын гадарга									

5	Хүн машины хөдөлгөөний улмаас хөрсөн бүрхэвч талхлагдах, хөрсний эвдрэл нэмэгдэх	Тээврийн хэрэгслийг зөвхөн 1 тогтсон замаар явуулах, олон салаа зам үүсгэхгүй байх	Замууд	-	-	-	-	Үйл ажиллагааны явцад	
6		Агуулахаас төв зам хүртэлх замын сүлжээг сайжруулсан шороон зам болгох, шороон замыг дагтаршуулах	Шороон зам	км	-	-	1,900,000 ₮	Үйл ажиллагааны явцад	
7	Химийн бодисыг асгаралт	Болзошгүй байдлаар шатах тослох материал, химийн бодис алдагдсан тохиолдолд шингээгч, хуурай элс, тогтворжуулагч, үртэс зэрэг саармагжуулах хэрэгслийг бэлэн байлгах.	Агуулахын талбай	Иж бүрдэл	Осол эрсдэлийн менежментийн хэсэгт тусгагдсан			2021-2025 оны хооронд жил бүр	
Ургамлан нөмрөг									
8	Химийн бодис тээвэрлэх зөөх ачиж буулгах үед хүн машины хөдөлгөө ургамлан нөмрөг талхлагдах	Төслийн нийт эзэмшлийн талбайн 20 хувиас багагүй талбайд олон наст ургамал тарьж, зүлэгжүүлэх, мод тарих ажлыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хийж гүйцэтгэх			-	500 ш суулгац	1 500 000 ₮	Ногоон байгууламжинд модны суулгац авч өгсөн.	
9		Олон салаа зам гаргахгүй байх, тогтсон маршрутаар тээврийн хэрэгслийг зорчуулах	Агуулахын ойр орчмын талбай	-	-	-	-	Үйл ажиллагааны турш	
Нийт							6,621,719 ₮		

4.5 Ногоон байгууламжийн тайлан

Төслийн нийт эзэмшлийн талбайн 20 хувиас багагүй талбайд олон наст ургамал тарьж, зүлэгжүүлэх, мод тарих ажлыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хийж гүйцэтгэх шаардлагатай гэж тусгагдсан боловч онцгой объект тул ургамал өвс ургуулж болохгүй учир дүүргийнхээ Цэцэрлэгжүүлэлтийн санд 1 500 000 төгрөгийн суулгац худалдаж авч өгсөн.

Мөн дүүргийн эмнэлэгийн хашаанд 200 ш суулгац суулгаж хүлээлгэж өгсөн.

Хүснэгт 5. Ногоон байгууламжийн тайлан

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Төслийн талбайд элэгдэл, эвдрэлд өртсөн газрыг олон наст ургамал тарьж, зүлэгжүүлэх, мод, бут, сөөгийг тарьснаар орчны өнгө үзэмжийг сайжруулж тохижуулах	Модны суулгац авах, суулгах	200ш суулгац суулгах				1 500 000	2022 онд	MNS5916-2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт”, MNS 5914:2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт
Нийт						1,500,000 ₮		

4.6 Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах тайлан

Химийн бодис, пиротехникийн агуулах байрлаж буй нутаг дэвсгэрт амьтны аймгийн төрөл зүйл нутагшилт, шилжих хөдөлгөөн нь бүрэн алдагдсан. Иймд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах талаар байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд боловсруулах шаардлагагүй гэж үзэв.

4.7 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох тайлан

Төслийн үйл ажиллагааны хүрээнд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох үйл ажиллагаа явагдаагүй.

4.8 Түүх, соёлын өвийг хамгаалах тайлан

Төсөл хэрэгжих талбай орчимд аливаа түүх соёлын өв, дурсгалт олдвор хэмжигдээгүй бөгөөд хэрвээ барилгажилтын үеийн газар шорооны үед олдвор олдвол Соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу арга хэмжээ авах, олдворыг гэмтээхгүйгээр үйл ажиллагааг түр зогсоох шаардлагатай.

Төсөл хэрэгжих талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй. Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад соёлын өв олдсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.

Хэрэв үйлдвэрийн үйл ажиллагааны явцад соёлын өв илэрсэн олдсон тохиолдолд үйлдвэрийн үйл ажиллагааг түр зогсоон холбогдох мэргэжлийн байгууллагаар авран хамгаалах малтлага судалгааг хийлгэх нь зүйтэй.

4.9 Хог хаягдлын менежментийн тайлан

Төслийн талбайд ажилчид байрлахгүй бөгөөд зөвхөн харуул хамгаалалтын ажилчид ээлжээр ажиллах юм. Химийн бодис зөөвөрлөх ачиж буулгах явцад түр ажилчид тухай бүрд нь ирж ажиллах бөгөөд ахуйн хог хаягдал маш бага хэмжээтэйгээр үүсэж болох юм. Харин зарим тохиолдолд химийн бодисын сав баглаа боодлын хог хаягдал гарах ба энэ төрлийн хог хаягдлыг Төв аймгийн Сэргэлэн сумын I багийн нутаг, IV зөрлөгийн орчимд химийн хорт болон аюултай бодисын сав, баглаа боодол дахин боловсруулдаг “Түмэн эгшиг” ХХК-тай химийн бодисын хаягдал, баглаа боодол шилжүүлэх гэрээ хийнэ ажиллаж байна.

Хог хаягдлын сөрөг нөлөөлөл болон түүний хэмжээг бууруулах менежментийн хүрээнд 2022 онд **3,240,000** төгрөг зарцуулсан.

Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн тайлан

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн	Химийн бодис ачиж буулгах түр ажилчдад зориулан агуулахын гадна талд хогийн сав байрлуулах	Агуулахын талбай	ш	500,000	1	-	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
		Хог хаягдлыг ангилан ялгаж аль болох богино хугацаанд төслийн талбайгаас тогтмол зайлуулж байх.	Агуулахын талбай	удаа	Нэг удаа тээвэрлэхэд 120 000	2	240,000	2022 онд	
		Төслийн талбай орчмын эргэн тойронд 50 м зайд цэвэрлэгээ хийх	Агуулахын орчимд 50 м	удаа	-	5	-	2022 онд	
2.	Аюултай	Химийн бодисын сав баглаа боодлын хог хаягдал гарсан тохиолдолд аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь түр хадгалан тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад өгөх	Агуулахын талбай	Удаа	Гүйцэтгэлээр		3,000,000	2022онд Тогтмол гэрээнд заасан хугацаанд	
		Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь түр хадгалахдаа тусгайлсан талбай бэлдэж, ангилан ялгаж хадгалах сав нэг бүр дээр нь Аюултай хог хаягдал гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн байна.	Агуулахын талбай	Удаа		1	-	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Нийт							3,240,000 ₮		

4.9 Осол, эрсдэлийн менежментийн тайлан

Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн тайлан

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн зардал төг	Тоо хэмжээ	Нийт зардал (төг/5 жил)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	2	3	5	6	7	8	9
Үер	Төслийн эзэмшил талбайг хаврын шар ус, хур бороо элбэгтэй үед үерт автахаас сэргийлж ус зайлуулах суваг хоолой, даланг технологийн дагуу мэргэжлийн байгууллагаар хийлгэх нь зүйтэй.	Агуулахын талбай	Гүйцэтгэлээр	-	1,500,000	Үерийн суваг татаж, засаж сайжруулсан	
Агуулахын ажиллагаанаас болзошгүй агуулахад осол аваар гарах, үйл гэнэтийн байдлаар	Химийн бодис тээвэрлэх, ачиж буулгах ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Ажилчид	100,000	5 ажилтан	1,155,000	Улирал солигдоход	
Химийн бодисын асгаралт	Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах хэрэгслийг байрлуулах. /элс хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг	Агуулахын талбай	Иж бүрэн	1 удаа	150,000	2022 оны хооронд жил бүр	

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн зардал төг	Тоо хэмжээ	Нийт зардал (төг/5 жил)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Химийн бодис тээвэрлэлт	Химийн бодисыг тээвэрлэхдээ "Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам"-ын дагуу тээвэрлэх, энэ талаар жолооч (2 жолооч) нарт сургалт зохион байгуулах шаардлагатай. Мөн шороон замаар 30 км/ц, хатуу хучилттай замаар 60 км/ц хурдтай явах талаах жолооч нарт анхааруулах	Ажилчид	Гүйцэтгэлээр	-	-	Үйл ажиллагааны туршид	
Агуулахад хадгалах химийн бодисыг зохих стандартын дагуу хадгалаагүй, хүний буруутай болон байгалийн гамшигт үзэгдлээс үүдэн агуулахад осол гарах, химийн бодис тэсэрч дэлбэрэх галын аюул гарах эрсдэлтэй.	Ямар нэгэн байдлаар ажилчид химийн бодист хордсон тохиолдолд анхны тусламж үзүүлэх зорилгоор норсульфазол, риванол, фурацилины уусмал, стретоцид, синтомицины эмульс, пенциллин, новокайн, дикайн адреналин, вишневскийн болон нафталины тос зэрэг эм бэлдмэл, бусад тос, уусмалуудыг бэлтгэн ашиглахад бэлэн байлгах	Төслийн талбай дээр түр ажиллах ажилчид болон харуул хамгаалалт ойр орчмын ард иргэд	Үйл ажиллагааны зардал тусгах	-	-	Үйл ажиллагааны туршид	
НИЙТ ЗАРДАЛ					2,805,000 ₮		

Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Хүснэгт 8. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан
1	Химийн бодис тээвэрлэх, ачиж, буулгах ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Осол эрсдэлийн МТ-нд тусгагдсан	2022 онд	Үйл ажиллагааны менежер

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан
2	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ -нд хүргэн өгч байх	Үйл ажиллагааны зардалд тусгах	2022 оны 8 сард	Үйл ажиллагааны менежер
3	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 2-р бүлгийн 101 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу байгаль орчны аудитыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хоёр жил тутам хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлэх	7,000,000	2022 онд	Үйл ажиллагааны менежер
4	Тусгай зөвшөөрөлтэй талбайд газрын төлөв байдлын чанарын улсын хянан баталгааг тогтоосон хугацаанд эрх бүхий байгууллагаар хийлгэж байх	1,500,000	2022 онд	Үйл ажиллагааны менежер
Нийт зардал			8,500,000 ₮	

4.10 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж ийн тоо	Нэгжийн зардал	Нийт зардал, төг 2022 онд	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Агаарын чанар						
<ul style="list-style-type: none"> Орчны тоосжилт (PM_{2.5}, PM₁₀ TSP) <ul style="list-style-type: none"> - Агаарын температур - Харьцангуй чийг Агаар бохирдуулагч хий (SO₂, NO₂), Гадаад болон дотоод орчны дуу чимээ 	Салхины зонхилох чиглэл болон эх үүсвэрүүдийн ойролцоо. Мөн агуулахын дотоод агаарын хэмжилтийг хийх	Жилд 1 удаа 2 цэгт хэмжилт хийх	2 цэгт	108,000	108,000	
Хөрсөн бүрхэвч						
Ялзмаг, урвалын орчин (pH), давсжилт, карбонат (CaCO ₃), хөдөлгөөнт кали (K ₂ O), хөдөлгөөнт фосфор (P ₂ O ₅), механик бүрэлдэхүүн	Агуулахын хашаан дотор химийн бодис буулгах талбайн ойр орчимд болон бусад шаардлагатай талбайд	Жилд 1 удаа дор хаяж 2 цэгт дээжлэлт хийж лабораторийн	2 цэгт	300,000	300,000	

Хар тунгалаг (Pb), кадми (Cd), хром (Cr), цайр (Zn), никель (Ni), Мөнгөн ус (Hg), цианид натри, хүнцэл (As)		шинжилгээнд өгнө.				
Нийт зардал						408,000 ₮


Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

ДУГНЭЛТ

Очир Ундраа ХХК нь Нийслэлийн Налайх дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “Химийн бодис, пиротехникийн хэрэгслийн” агуулахад 2018 оноос үйл ажиллагаа явуулж байна. 2021 онд цар тахлын улмаас үйл ажиллагаагаа явуулаагүй бөгөөд 2022 онд үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. 2022 онд хийсэн нийт ажлуудын зардлууд **23,0747,719** төгрөг болсон байна.

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

№	Хавсралтын нэр	Хуудасны тоо
1	Агаарын чанарын шинжилгээ	1
2	Хөрсний шинжилгээ	1
3	Нөхөн сэргээлт /модны суулгац/	1
4	Аюултай хог хаягдал усгах гэрээ маягт	6



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№	: 2022/A-316
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Очир Ундраа” ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал	: Б.Батхишиг агаарын хэсэг
Дээжийн тоо, төрөл	: 2 агаар ,2 дуу чимээ
Сорьц авсан огноо	: 2022.10.27
Дээжийн тодорхойлолт	: Налайх дүүрэг 3-р хороо химийн бодис протектийн хэрэглээний агуулах
Шинжилгээний аргын стандарт	: MNS 0017-2-5-12:2021, MNS 0017-2-5-11:2021 CA3 A07-2016
Шинжилсэн огноо	: 2022.10.31
Хуудасны тоо	: 1/1
Үр дүн :	

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Нийт Тоос /TSP/ мг/м ³	Дуу чимээ /ДБА/
1	Агуулахын салхин доор	X/27	09:05	0.013	0.022	0.055	45
2	Агуулах орчим	X/27	09:30	0.015	0.024	0.060	40
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн:
Агаарын хэсгийн инженер

Хянаж баталгаажуулсан:
Агаарын хэсгийн инженер



Э.Оюунтуяа

Д.Түмэндэлгэр

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй



**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН
ХӨРСНИЙ ЛАБОРАТОРИ**

Хаяг: Монгол улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг,
7-р хороо, Эрхүүгийн гудамж, 11-р хороолол

Утас: +976 99141955

E-mail: soillab.IGG@gmail.com

Хөрсний задлан шинжилгээний дүн

Дээж авсан газрын нэр: Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 3-р хороо,
"Очир-Ундраа" ХХК-ийн химийн бодисын агуулах

Дээж шинжлүүлсэн байгуулага, хувь хүн: "Баялаг эко" ХХК

Шинжилгээ хийсэн огноо: 2022 он 04 сар 29

Хөрсний химийн үндсэн шинж

№	Дээжний дугаар	Гүн, см	pH _{N,0} (1:5)	CaCO ₃ %	Ялзмаг %	EC _{2.5} dS/m	Хөдөлгөөнт, мг/100г	
							P ₂ O ₅	K ₂ O
1	Дээж-1	0-10	7.66	0.00	2.020	1.604	1.63	21.5

Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Дээжний дугаар	Гүн, см	Ширхэгийн хэмжээ, % (мм-ээр)		
			Элс (2-0.05мм)	Тоос (0.05-0.002мм)	Шавар (< 0.002мм)
1	Дээж-1	0-10	65.8	23.4	10.8

Товч дүгнэлт:

Хөрс нь сул шүлтлэг урвалын орчинтой, карбонатгүй, ялзмагийн агууламж дунд зэрэг, цахилгаан дамжуулах чанар бага зэрэг буюу бага зэрэг давсжилттай, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар дунд зэрэг, механик бүрэлдэхүүн элсэнцэр. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин дундаж.

Шинжилгээний арга

pH, EC-MNS ISO 10390:2001- Ионметр, кондуктометр

CaCO₃-Кальциметр (10% HCl)


Ялзмаг-Тюрин (Walkley & Black)

Хөдөлгөөнт фосфор, кали-Спектрофотометр, Дөлөн фотометр-Мачигин (1% (NH₄)₂CO₃)

Хөрсний механик бүрэлдэхүүн-Гидрометрийн арга

Хөрсний лабораторийн эрхлэгч, доктор  Х.Золжаргал





**ХӨРС СУДЛАЛЫН
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**



ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn

Дугаар: 22/1504

Дээж авсан огноо: 2022 он 04 сарын 26

Шинжилгээ хийсэн огноо: 2022 он 04 сарын 27-28

Дээж авсан газрын нэр: Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 3-р хороо, “Очир-Ундраа” ХХК, химийн бодисын агуулах

Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “Баялаг Эко” ХХК

Харилцах утас: 94923999

Хөрсний хүнд металл

№	Лаб/ дугаар	Дээжний нэр	Гүн, см	Хүнд металл мг/кг					
				Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/
1	22/2761	Дээж-1	0-10	49.1	0.02	33.5	28.4	60.8	5.34
Хүлцэх агууламж /MNS 5850:2019/				150,0	3,0	100,0	100,0	300,0	150,0
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт				/MNS 5850:2019/					

ND-not detect

Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.

Шинжилгээ хийсэн арга стандарт:

(MNS ISO 11466:2007)

Лабораторийн эрхлэгч:  Л. Цагаандархи /MS.cl-2

Задлан шинжээч:  Х.Жаргалмаа



БАТЛАВ.
“ТҮМЭН ЭГШИГ” ХХК
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

..... /Г.ЧИНЗОРИГ/

БАТЛАВ.
“ӨЧИР УНДРАА” ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

..... /Г.МӨНХЗУЛ/

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны 05 сарын 01-ний өдөр

№ОУ-ХА-01/04/2022

Улаанбаатар хот

Нэг талаас Түмэн эгшиг ХХК /цаашид “Хүлээн авагч” гэх/ төлөөлж Үйлдвэр хариуцсан дарга албан тушаалтай Б.Одбаяр, Нөгөө талаас Очир Ундаа ХХК-г /цаашид “Үүсгэгч” гэх/ төлөөлж худалдааны мэргэжилтэн албан тушаалтай Д.Туяацэцэг бид харилцан тохиролцож Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний агуулга

- 1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичгийн дагуу түүнээс гарч байгаа аюултай хог хаягдлыг хүлээн авагч нь хүлээн авч хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.
- 1.2. Эл гэрээгээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол улсын Хог хаягдлын тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3. Аюултай хог хаягдлын тоо хэмжээ, төрөл болон үнийн талаар гэрээний Хавсралт 1-т тусгах ба талууд гэрээний хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ дагалдах бичгийг гэрээнд хавсаргах ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

Хоёр. Аюултай хог хаягдалд тавигдах шаардлага

- 2.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж “Аюултай хог хаягдал” гэсэн тэмдэглэгээтэй байна.
- 2.2. Аюултай хог хаягдал савласан сав бүр нь ямар химийн бодис хадгалж байсан тухай нэр шошготой байна.
- 2.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаарх бүртгэлийг хүлээн авагчид шилжүүлнэ.
- 2.4. Аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ **БОАЖЯ Сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалын 1-р хавсралтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг** бүрдүүлж өгнө.
- 2.5. Аюултай хог хаягдлын савыг суллаж онц хортой, тэсрэмтгий, шатамхай бодис /тухайлбал цианид натри гэх мэт/ -г тухайн бодисны шинж чанарт тохирсон уусмалаар цэвэрлэсэн байна. Хоосон сав нь ЗГ-н 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын 5.7-5.9-д заасан шаардлагыг хангасан байвал зохино.
- 2.6. Үүсгэгч Аюултай хог хаягдлыг “Аюултай хог хаягдал” тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий Аж ахуй нэгжийн тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлж хүлээн авагчид шилжүүлнэ.



Гурав. Аюултай хог хаягдлыг шилжүүлэх хугацаа, төлбөр төлөх нөхцөл

- 3.1. Гэрээний үргэлжлэх хугацаа нь 2022 оны 05 сарын 01 өдрөөс 2023 оны 05 сарын 01 өдрийг хүртэл 1 /нэг/ жилийн хугацаатай байна.
- 3.2. Эхний нийлүүлэлт нь гэрээ байгуулагдсанаас хойш 10 хоногийн дотор үүсгэгч нь хүлээн авагчид шилжүүлсэн байна.
- 3.3. Энэхүү гэрээний 1-р хавсралтад заасан Үүсгэгчээс гарах хаягдлын урьдчилсан төлөвлөгөөний дагуу аюултай хог хаягдалын хуримтлал үүссэн тохиолдолд үүссэн хаягдлын хэмжээнээс хамаарч 90-ээс 180 хоногт аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлсэн байна.
- 3.4. Үүсгэгч нь аюултай хог хаягдлаа шилжүүлэх тухай хүсэлтээ хүлээн авагчид албан бичгээр эсвэл chemicalwasterisk@gmail.com хаягаар 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ. Хүлээн авагч тал үүсгэгч болон тээвэрлэгчтэй харилцан тохиролцож хүлээн авагчийн байранд аюултай хог хаягдал хүргэх хугацааг товлон.
- 3.5. Хүлээн авагч нь үүсгэгчээс аюултай хог хаягдал шилжин ирэх товлосон өдөр, цагт аюултай хог хаягдлыг хүлээн авах хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.
- 3.6. Аюултай хог хаягдлыг хүлээн авагч хүлээн авах үед үүсгэгчээс ирүүлсэн дагалдах бичигт дурдсан мэдээлэл зөрсөнөөс үүдэж гэрээний үнэ өөрчлөгдөж болно. Энэ тохиолдолд хог хаягдлыг хүлээн авах үед тооцож гаргасан үнээр бодож үүсгэгч хүлээн авагчид төлбөрийг төлнө.
- 3.7. Үүсгэгч нь гэрээний төлбөрийг аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэх тухай захиалга өгсөнөөс хойш ажлын 3 хоногийн дотор Түмэн эгшиг ХХК-ийн **Худалдаа хөгжлийн банк 499085408** тоот дансанд төлбөрийн нэхэмжлэхийн дагуу 100 хувь төлнө.
- 3.8. Үүсгэгч нь хүлээн авагчийн тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр аюултай хог хаягдлыг тээвэрлүүлж, хүргэлтийн цэг дээр хүргүүлж болно. Хүлээн авагчийн тээврийн хэрэгслээр хог хаягдал ачиж, тээвэрлүүлэх тохиолдолд тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулан, гэрээний дагуу зохих төлбөрийг төлнө.

Дөрөв. Талуудын эрх, үүрэг

- 4.1 Үүсгэгчийн эрх, үүрэг:
 - 4.1.1 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа гэрээнд заасан хугацааны дотор хүлээн авахыг хүлээн авагчаас шаардах эрхтэй.
 - 4.1.2 Үүсгэгч нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүлээлгэн өгнө.
 - 4.1.3 Үүсгэгч нь Аюултай хог хаягдлын дагалдах бичгийг 2 хувь үйлдэж, гарын үсэг тамга тэмдэг дарж өөртөө бичгийг буцаан авна.
 - 4.1.4 Аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүргэх тээврийн зардлыг хариуцна.
 - 4.1.5 Үүсгэгч Аюултай хог хаягдлыг хүлээн авагчаар тээвэрлүүлэхээр бол тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулах харилцан тохиролцож шилжүүлнэ.
 - 4.1.6 Гэрээгээр тохиролцсон төлбөрийг хүлээн авагчид хугацаанд нь төлнө.
 - 4.1.7 Шилжүүлэх аюултай хог хаягдлын талаарх мэдээллийг хүлээн авагчид үнэн зөв мэдээлнэ. Худал, буруу ташаа мэдээлсэнээс бусдын эрүүл мэнд, амь нас, талуудын эд хөрөнгө болон байгаль орчинд хохирол учирвал үүнээс үүсэх хохирлыг үүсгэгч тал хариуцна.
 - 4.1.8 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа хүлээн авагчид шилжүүлэх тухайгаа 5-аас доошгүй хоногийн өмнө хүлээн авагчид мэдэгдэнэ.

4.2 Хүлээн авагчийн эрх, үүрэг

- 4.2.1 Үүсгэгчээс Гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авах
- 4.2.2 Үүсгэгчээс шилжүүлсэн аюултай хог хаягдал нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангаагүй, дагалдах бичигт үл зохицол үүссэн, тоо, хэмжээтэйгээ зөрж байвал уг хаягдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзах эрхтэй.
- 4.2.3 Үүсгэгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр аюултай хог, хаягдлыг гэрээнд заасан буюу товлосон хугацаанаас 30-аас дээш хоногоор хүлээн авагчид шилжүүлэлгүй хоцроовол хүлээн авагч тал гэрээг нэг талын санаачлагаар цуцлах эрхтэй.
- 4.2.4 Аюултай хог хаягдал хүлээн авсан төлбөр тооцоог үүсгэгчээс гэрээнд заасан хугацааны дотор төлөхийг шаардах эрхтэй.
- 4.2.5 Аюултай хог хаягдлыг хүлээж авсан актыг үүсгэгчид гаргаж өгнө.
- 4.2.6 Хүлээн авагч аюултай хог хаягдлыг хүлээн авсанаас хойшхи түүний хадгалалт, устгал, дахин боловсруулалтыг хариуцна.
- 4.2.7 Үүсгэгчээс Аюултай хог хаягдал шилжиж ирэх үед хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.

Тав. Аюултай хог хаягдлыг шилжүүлэх, шилжүүлэн авах

- 5.1. Үүсгэгч гэрээгээр тохиролцсон хугацаандаа аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг буюу Төв аймаг, Сэргэлэн сум, 4-р багийн нутаг дэвсгэрт орших “ТҮМЭН ЭГШИГ ХХК БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР”-т хүргэнэ.
- 5.2. Үүсгэгч гэрээнд заасан шилжүүлэх хугацаанаасаа өмнө аюултай хог хаягдлыг шилжүүлэх эрхтэй ба ингэх тохиолдолд Хүлээн авагчид энэ тухай 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдсэн байна.
- 5.3. Үүсгэгч аюултай хог хаягдлаа “Аюултай хог хаягдал” тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн тусгай зориулалтын, зохих тэмдэг тэмдэглэгээтэй тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлэн Хүлээн авагчид хүргэж өгнө.
- 5.4. Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэхдээ дагалдах бичиг болон гэрээнд заасан тоо, хэмжээтэй нийцэж байгаа эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалгах ба нийцэж байвал энэ тухай акт үйлдэж гарын үсэг зурж хүлээн авагч тал хүлээн авна.
- 5.5. Аюултай хог хаягдал нь гэрээний 4.2.2-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд хүлээн авагч хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзаж болно. Энэ тохиолдолд Аюултай хог хаягдлыг үүсгэгчид буцааж хүргэхтэй холбогдон гарах зардлыг үүсгэгч тал хариуцна.

Зургаа. Өмчлөх эрх шилжих

- 6.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл хог хаягдлын өмчлөгч байна.
- 6.2. Үүсгэгч нь хог хаягдлыг хүлээн авагчид ачиж, тээвэрлэн хүлээн авах цэг дээр хүлээлгэн өгснөөр өмчлөх эрх хүлээн авагчид шилжсэн гэж үзнэ.
- 6.3. Аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг дээр хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл түүний үр шим, эрсдэл үүсгэгчид байх ба хүлээн авагчид хүлээлгэн өгснөөр үр шим, эрсдэл хүлээн авагчид шилжинэ.



Долоо. Хариуцлага, маргаан шийдвэрлэх журам

- 7.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа учирсан аливаа хохирлыг холбогдох нотлох баримтад үндэслэн бүрэн хариуцаж нөхөн төлнө.
- 7.2. Үүсгэгч энэ гэрээний 3.8-д заасны дагуу үнийг төлөх хугацааг хэтрүүлсэн бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Хүлээн авагчид төлнө.
- 7.3. Хэрэв Хүлээн авагч нь Үүсгэгчээс ирүүлсэн хог хаягдлыг энэ гэрээний 3.4-т заасан хугацааны дотор зохих журмын дагуу хүлээн аваагүй, хугацааг хожимдуулсан бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гэрээгээр тохиролцсон үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Үүсгэгчид төлнө.
- 7.4. Алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10%-аас хэтрэхгүй байна.
- 7.5. Талууд гэрээнээс татгалзах болон цуцлах үндэслэлийг иргэний хуулиар зохицуулна.
- 7.6. Үүсгэгч тал аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэхдээ дагалдах бичиг болон гэрээний хавсралт 1-д заасан тоо хэмжээ, химийн бодисын нэр хаягийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй бөгөөд буруу, зөрүүтэй худал мэдээлсэнээс болж гэрээний үнийн дүн өөрчлөгдөх, эсвэл үүнээс үүдэж хохирол учирвал хүлээн авагч хариуцахгүй болно.
- 7.7. Энэ гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Найм. Давагдашгүй хүчин зүйл

- 8.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, зуд болох, тахал болон бусад байгалийн хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа, төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт, импортын хориг, ажил хаялт, үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул зогсолт зэрэг талуудын үйл ажиллагаанаас үл хамаарах үндэслэлээр энэхүү гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.
- 8.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй тохиолдолд талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээний хугацаа дээрх нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгагдах буюу тодорхой хугацаа зааж сунгаж болно.
- 8.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бараа материал утсан, дутсан тохиолдолд шилжүүлэн хүлээлгэн өгөх хүртэлх эрсдэлийг үүсгэгч, шилжүүлэн хүлээн авснаас хойшхи эрсдэлийг хүлээн авагч хариуцна.
- 8.4. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд форс мажорын нөхцлөөс шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.

Ес. Бусад зүйл

- 9.1. Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

- 9.2. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулах ба талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.3. Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, Үүсгэгч тал 1 хувь, Хүлээн авагч тал 1 хувийг тус тус хадгалсан нь хуулийн ижил хүчинтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Үүсгэгч талыг төлөөлж:

НЯГТЛАН БОДОГЧ

Д.Оюунбилэг

ХУДАЛДААНЫ МЭРГЭЖИЛТЭН

Д.Туяацэцэг

Суурин утас: 75757979

Гар утас: 99908894

Регистер: 2659603

Химийн бодис ашиглах, импортлох тусгай зөвшөөрлийн дугаар: 0001775

Хаяг: СБД-8-хороо Чингэсийн өргөн чөлөө Сити Тауэр 17 давхар

Email хаяг: tuyatsetseg.d@ochir-undraa.mn

Хүлээн авагч талыг төлөөлж:

ТҮМЭН ЭГШИГ ХХК-ийн
ЕРӨНХИЙ МЕНЕЖЭР

ТҮМЭН ЭГШИГ ХХК
/ Б.Одбаяр /

Суурин утас: 77110428

Гар утас: 92050001, 88990428

Регистер: 5031923

УБ гэрчилгээний дугаар:

Тусгай зөвшөөрлийн дугаар: Б-000001

Хаяг: Баянзүрх дүүрэг, 14-р хороо,
Намъянжугийн – 44, Түмэн эгшиг ХХК-ийн, өөрийнбайр

Email хаяг: chemicalwasterisk@gmail.com

Шуудангийн хаяг: 51 салбар 499 тоот



Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2018 оны 02 сарын 02-ны өдрийн А/21 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ

№ *01/000189*

Дагалдах бичгийн дугаар:

/шаардлагатай тохиолдолд нэмэлт хуудас хэрэглэнэ./

1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл:
Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар:
Аюултай хог хаягдал үүсгэгч байгууллагын нэр: *Оюу Чираа ХХК*

2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн:
Овог нэр: *Х.Түвшин* Албан тушаалтан: *Хуу. Хэлт. Түвшин* Гарын үсэг: Огноо: 2022 он *10* сар *30* өдөр

3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:
1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар: *37-204EM* Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар: *070022*

4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:

	Аюултай хог хаягдлын нэр	Аюулын ангилалын зэрэглэл	Савлагааны бүлэг	Савны		Хэмжээ	Нэгж /кг Эсвэл/ ш	Аюултай хог хаягдлын код
				дугаар	Төрөл			
1	<i>Хөдсгөл шүүвэл</i>	<i>X</i>				<i>5158</i>	<i>кг</i>	
2								
3								
4								

3. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:

5. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч: *Түвшин Түвшин ХХК*

1. Овог нэр: *Б.Огддор* Гарын үсэг: *Б.Огддор* Огноо: 2022 он *10* сар *30* өдөр

6. Үл зохицол:

8. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчийн талаарх мэдээлэл:
Аж ахуйн нэгжийн нэр: **ТҮМЭН ЭГШИГ ХХК**
Түмэн эгшиг ХХК бүртгэлийн дугаар: **-00001**
Аюултай хог хаягдлыг хүлээн авсан:
Овог нэр: *Түмэн эгшиг ХХК* Албан тушаал: *Түвшин* Гарын үсэг/тамга/ Огноо: 2022 он *10* сар *30* өдөр



Хүсэлтийн давлах дугаар: 119170108

Татсан огноо: 2022-10-31 16:51

Шилжүүлэгчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
1905003694 IBAN: MN30 0015 0019 0500 3694	5779019168	1,500,000.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр ОЧИР-УНДРАА ХХК	Хүлээн авагчийн нэр НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН АЛБА	Гүйлгээний утга Модны суулгац /2659603/	
	Хүлээн авагчийн банк Хаан банк	Гүйлгээний огноо 2022-05-16	

